

БДБ-7 Ажилчид

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-7

БДБ-7 маягтаар тухайн сургуульд Төрийн албаны ангиллын дагуу ажиллаж байгаа ажиллагчдыг удирдах, үйлчилгээний ажиллагчид гэсэн ангилал буюу албан тушаал тус бүрээр нь гаргана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-7	ЕБС-ийн ажилчдын тайлан (хүйс)	Хүний нөөцийн удирдлага хэсгийн Ажлын байр, Ажилтны жагсаалт модульд бүртгэл хийгсээр гарна.
2	БДБ7А	ЕБС-ийн ажилчдын тайлан (сургууль, хүйс)	Ямар ажлын байранд хичнээн хүн бүртгэлтэй байгааг харна.
3	БДБ7_1А	Албан бус боловсролын гэгээрэл хөгжлийн төвийн ажилчдын тайлан (сургууль)	Тухайн сургууль нь албан бус боловсрол эзэмшүүлдэг бол түүний ажилчдын ажлын байрны тоог харуулна.
4	БДБ7_1	Албан бус боловсролын гэгээрэл хөгжлийн төвийн ажилчдын тайлан	Албан бус боловсролын төвийн ажилчдын нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг гэх мэт бүртгэлийг харна.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Бүртгэлээр

Статистикийн удирдлага -ийн статистикийн хяналт хэсэгт орно.

Хяналтын хэсэгт хичээлийн жил болон тайлант үеийг сонгоно.

Нэгтгэл цонхноос **Ажилтан** гэсэн утгыг дуудна. Ингэснээрээ танай сургуулийн ажилчдын тоо нэгдсэн байдлаар харагдана.

Жагсаалт гэсэн хэсгээс ажилтан тус бүрийн албан тушаалын мэдээллийг харж болно.

